

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1."Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт даалгасугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувиллыг сонгон шалгаруулах журам батлах, сувиллын санхүүжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 06 дугаар тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

**ДААТГУУЛАГЧИД ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ СЭРГЭЭН ЗАСАХ ТӨВ БОЛОН
СУВИЛЛЫГ СОНГОХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, САНХҮҮЖҮҮЛЭХ, ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРТ ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсэгт заасныг үндэслэн даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувилал /цаашид “сувилал” гэх/-г сонгох, гэрээ байгуулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.

1.2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалт нь Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Эрүүл мэндийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Өрсөлдөөний тухай, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, энэ журмаар зохицуулагдана.

1.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалт явуулах хугацаа, сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагад тавигдах шаардлага, оролцогч байгууллагын бүрдүүлэх баримт бичиг, үнэлэх арга, үнэлгээний хуудсаар үнэлж шалгаруулна.

1.4.Сэргээн засах өтөв болон сувиллын тусламж үйлчилгээг даатгуулагчид тэгш, хүртээмжтэй үзүүлэх, даатгуулагчийн сувиллуулах дарааллыг зохицуулах, батлагдсан оноштой даатгуулагч хүлээн авах зорилгоор “Даатгуулагчийг сувилалд илгээх бичиг” (цаашид “Илгээх бичиг” гэх)-ийг цаасан эсхүл цахим хэлбэрээр явуулна.

1.5.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын магадлагч эмч болон салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь даатгуулагчид эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх Эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэрийг үндэслэн илгээх бичиг олгоно.

1.6.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтыг батлагдсан орны дээд хязгаарыг баримтлан бүсчилсэн хэлбэрээр, 4 жил тутамд зохион байгуулна.

1.7.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувилал нь Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилттэй давхцахгүй байна.

Хоёр.Сэргээн засах төв болон сувиллыг сонгон шалгаруулах

2.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сэргээн засах төв болон сувиллыг сонгон шалгаруулах ажлын хэсэг /цаашид “ажлын хэсэг” гэх/-ийн бүрэлдэхүүнийг байгуулна.

2.2.Ажлын хэсэг нь ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл тус бүр 1, эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл 1, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон төрийн бус байгууллагын төлөөлөл тус бүр 2, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.3.Ажлын хэсгийн дарга нь Төв зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга нь төв зөвлөлийн магадлагч эмч, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл нь нийгмийн даатгал болон эрүүл мэндийн асуудал хариуцсан газар, төрийн бус байгууллагын төлөөлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагын төлөөлөл тус тус байна.

2.4.Энэхүү журмын 2.2-т заасан ажлын хэсгийн бүрэлдэхүүний бүх гишүүд төрийн худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сургалтын эрхтэй байна.

2.5.Сэргээн засах төв болон сувиллыг сонгон шалгаруулах ажлын хэсгийг жил бүр шинээр байгуулж ажиллана.

2.6.Ажлын хэсэг нь сэргээн засах болон сувиллын сонгон шалгаруулалтыг дараах дэс дарааллаар явуулна:

2.6.1.сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалт явуулах тухай зарыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулах, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод нээлттэй зарлан мэдээллэх;

2.6.2.сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтад ирүүлсэн баримт бичгийн бүрдэлтийг шалгаж, ажлын хэсгийн хурлыг хуралдуулж, танилцуулах;

2.6.3.ажлын хэсэг нь сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтад ирүүлсэн баримт бичиг бүртэй танилцаж, сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагад тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлт, үнэлэх аргын дагуу үнэлгээний хуудсаар үнэлж үнэлгээ өгөх;

2.6.4.ажлын хэсэг нь баримт бичгийн шаардлага хангасан сэргээн засах төв болон сувиллын үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, үнэлгээ хийх;

2.6.5.сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтыг хууль, тогтоомж, журмыг баримтлан заасан хугацаанд, сонгон шалгаруулалтын нэгдсэн дүнг гаргах;

2.6.6.сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтад оролцсон байгууллагуудад мэдэгдэл, албан бичиг хүргүүлэх;

2.6.7.сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, гишүүд гарын үсэг зурж, баталгаажуулан Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргад танилцуулах.

2.7.Ажлын хэсгийн гишүүдийн 70-аас доошгүй хувийн ирцтэй хурлыг хүчинтэйд тооцох ба хуралдах бүртээ хурлын тэмдэглэл хөтөлж, сонгон шалгаруулалттай холбоотой аливаа асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.8.Сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтад тэнцэж гэрээ байгуулсан байгууллагын мэдээллийг Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд байршуулж нийтэд мэдээлнэ.

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагад тавигдах шаардлага

3.1.Сонгон шалгаруулалтад өмчийн бүх хэлбэрийн сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллага оролцоно.

3.2.Сонгон шалгаруулалтад оролцох сэргээн засах төв болон сувилал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.2.1.эрх бүхий төрийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд сэргээн засах, сувиллын тусламж, үйлчилгээг тогтвортой үзүүлдэг байх;

3.2.2. сэргээн засах төв болон сувилал нь “Рашаан сувиллын бүтэц үйл ажиллагааны MNS 5232:2019” стандартын А хавсралтад заасан хүний нөөцтэй байх;

3.2.3.сэргээн засах төв болон сувилал нь “Рашаан сувиллын бүтэц үйл ажиллагаа MNS 5232:2019” стандартын Б хавсралтад заасан эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;

3.2.4.сэргээн засах төв болон сувилал нь “Рашаан сувиллын бүтэц үйл ажиллагаа MNS 5232:2019” стандартын В хавсралтын 2 дахь хэсэгт заасан сэргээн засах эмчилгээг бүрэн үзүүлдэг байх;

3.2.5."Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНБД 31-23-22/ MNS 6055:2009 “Иргэний барилгын төлөвлөлтөл хөгжлийн бэрхшээлтэй иргэний шаардлагыг тооцсон орон зай, орчин” шаардлага хангасан байх;

3.2.6."Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056:2009 шаардлагыг хангасан байх;

3.2.7.хяналт шалгалтын эрх бүхий байгууллагаас тавьсан акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт бүрэн хангагдсан байх;

3.2.8.сувиллын анхан шатны бүртгэлийн баримт бичиг, статистик мэдээ, мэдээлэл, тайлан гаргах, мэдээлэл дамжуулах, нэхэмжлэх зэрэг үйл ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжсэн байх;

3.2.9.өмчлөлийн аль нэг хэлбэрийн ямар нэгэн маргаангүй байх;

3.2.10.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг сэргээн засах чиглэлээр үйлчлэх хүрээ, санхүүжих орны тоо, жилд сувилах даатгуулагчийн тоо, санхүүжилтийн хэмжээг урьдчилан тооцож, санхүүжилтийг сэргээн засах тусламж, үйлчилгээнд хэрхэн үр дүнтэй зарцуулах талаар тооцоо, судалгаа, хүрэх үр дүнг урьдчилан төлөвлөсөн байх.

Дөрөв.Сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагын бүрдүүлэх баримт бичиг

4.1.Сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтад оролцогч байгууллага нь дараах баримт бичгийг цаасан эсхүл цахимаар бүрдүүлнэ. Үүнд:

4.1.1.сонгон шалгаруулалтад оролцох тухай хүсэлт;

4.1.2.сэргээн засах төв болон сувиллын дэлгэрэнгүй танилцуулга /сувиллын байршил, тусламж, үйлчилгээний нэр төрөл, үндсэн үзүүлэлт, орны фонд ашиглалт, дундаж ор хоног, сувилуулагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тусгасан байна/;

4.1.3.улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

4.1.4.тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

4.1.5.магадлан итгэмжлэгдсэн тохиолдолд батламжийн хуулбар;

4.1.6.сэргээн засах төв болон сувиллын бүтэц, орон тоог баталсан холбогдох байгууллагын шийдвэр;

4.1.7.сэргээн засах төв болон сувиллын дотоод зохион байгуулалт, байршлын бүдүүвч зураг, гадна, дотор орчны фото зураг эсхүл видео бичлэг;

4.1.8.хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгаа /овог, нэр, албан тушаал, мэргэшлийн байдал, тус сувилалд ажилласан жил, эмчлэх, сувилах тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, мэргэжлийн диплом, үнэмлэхний дугаар, хуулбарын хамт/;

4.1.9.сэргээн засах төв болон сувиллын үйл ажиллагааны тайлан, тусламж, үйлчилгээний чанарын албаны төлөвлөгөө,тайлан;

4.1.10.багаж тоног төхөөрөмжийн жагсаалт, тоног төхөөрөмжийн баталгаажуулалт хийсэн гэрээний хуулбар;

4.1.11.нийгмийн даатгалын болон татварын өргүй тухай тодорхойлолт /сүүлийн сараар/;

4.1.12.харьяалах Эрүүл мэндийн газрын тодорхойлолт /сэргээн засах төв болон сувиллын үйл ажиллагааны тогтвортой байдал, тусламж, үйлчилгээний чанар, орны фонд эргэлт, сувилалтай холбоотой өргөдөл гомдол гарсан эсэх, түүний үндэслэл, шийдвэрлэлт, гэрээний биелэлт зэргийг тусгасан/;

4.1.13.нийгмийн даатгалын газар, Эрүүл мэндийн газар, Татвар, аудит зэрэг байгууллагаас хийсэн хяналт шалгалтын дүн, тайлан, тавьсан акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангаж ажилласан тайлан;

4.1.14.сонгон шалгаруулалтад оролцогч нь өмчлөлийн маргаангүйг нотолсон Улсын бүртгэлийн газар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цахим лавлагаа;

4.1.15.нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний учир хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид, хөдөлмөрийн чадвар алдалтыг сэргээн засах чиглэлээр үйлчлэх хүрээ, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих орны тоо, жилд сувилах даатгуулагчийн тоо, санхүүжилтийг сэргээн засах тусламж, үйлчилгээг хэрхэн үр дүнтэй зарцуулах талаар хийсэн тооцоо, судалгаа, хүрэх үр дүнг урьдчилан төлөвлөсөн байх.

Тав. Сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагыг үнэлэх, мэдэгдэх

5.1.Ажлын хэсгийн гишүүн бүр сонгон шалгаруулалтын нээлтийн үед техникийн санал нь дурдагдан, бүртгэгдсэн баримт бичиг бүртэй нэг бүрчлэн танилцаж, үнэлж дүгнэнэ.

5.2.Ажлын хэсгийн гишүүд ерөнхий, тусгай шалгуур үзүүлэлт болон нийт оноог тооцон дүгнэлт хэсэгт тэнцсэн эсэх талаар тэмдэглэж, гарын үсэг зурж баталгаажуулна.

5.3.Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь “Тэнцсэн”, “Тэнцээгүй” гэж дүгнэгдсэн оролцогчдын жагсаалтыг тус тусад нь гарган ажлын хэсгийн дарга, гишүүдэд танилцуулж, гарын үсэг зурж баталгаажуулан сэргээн засах төв болон сувиллын байгууллагад мэдэгдэнэ.

5.4.Сонгон шалгаруулалтад оролцогч нь тэнцээгүй тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гомдлоо бичгээр гаргаж болно. Гомдлыг 14 хоногийн хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

Зургаа. Сонгон шалгаруулалтад тэнцсэн сэргээн засах төв болон сувилалтай гэрээ байгуулах

6.1.Сэргээн засах төв болон сувиллын сонгон шалгаруулалтад тэнцсэн сэргээн засах төв болон сувиллын байгууллагатай Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн

захиргааны байгууллага нь “Даатгуулагчид сэргээн засах, сувиллын тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ” нэг жилийн хугацаатай байгуулна.

6.2. Даатгуулагчид сэргээн засах, сувиллын тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ”-нд даатгуулагчийн эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай тусламж, үйлчилгээний нэр төрөл, сувиллын орны дээд хязгаар, жилд сувилуулах даатгуулагчийн тоо, нийт ор хоног, нэг ор хоногийн зардлын хэмжээ, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх зардлын хэмжээ, талуудын хүлээх үүрэг, хариуцлага, гэрээний нөхцөл зэргийг заасан байна.

6.3. Сэргээн засах төв болон сувилал нь зайлшгүй шаардлагаар гэрээнд тусгагдаагүй нэмэлт, тусламж, үйлчилгээ гүйцэтгэх тохиолдолд тухайн үйлчилгээнд нэмэлт гэрээ байгуулж болно.

Долоо. Сонгон шалгаруулалтад тэнцсэн сэргээн засах төв болон сувиллыг санхүүжүүлэх

7.1. Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллын үйлчилгээ үзүүлэх байгууллагад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих хувьсах зардлын хэмжээгээр тооцож Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага холбогдох журамд заасны дагуу санхүүжүүлнэ.

7.2. Сэргээн засах төв болон сувилал нь батлагдсан төсөвтөө багтаан тухайн жилд үзүүлэх тусламж үйлчилгээг олон нийтэд ил тод мэдээлж, даатгуулагчийг сонголт хийх боломжоор хангана.

Найм. Сэргээн засах төв болон сувиллын тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих

8.1. Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, бусад мэргэжлийн байгууллага нь сэргээн засах төв болон сувиллын тусламж, үйлчилгээний чанар, сувиллын орны дээд хязгаар, жилд сувилуулах даатгуулагчийн тоо, нийт ор хоног, нийгмийн даатгалын байгууллагаас санхүүжүүлсэн зардлын хэмжээ зэрэгт холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.

8.2. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага сэргээн засах төв болон сувиллын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний чанар, сангийн зарцуулалтад хяналт тавьж ажиллана.

8.3. Сэргээн засах төв болон сувиллын ерөнхий эмч, чанарын алба, эмчлэгч эмч нь сувиллын өдөр тутмын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний чанарт тавих дотоодын хяналтыг хариуцна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв болон магадлалын төв зөвлөл сэргээн засах төв болон сувиллын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

8.4. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь эрүүл мэндийн болон бусад мэргэжлийн байгууллагатай хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулна.

Ес. Хариуцлага.

9.1.Нийгмийн даатгалын байгууллагатай “Даатгуулагчид сэргээн засах, сувиллын тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулан тусламж, үйлчилгээ үзүүлж буй сувиллын үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн явцын үнэлгээ болон эрх бүхий байгууллагын шалгалтаар ноцтой зөрчил дутагдал илэрсэн, гэрээнд заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн, гэрээний хэрэгжилтийг хангалтгүй дүгнүүлсэн тохиолдолд гэрээг цуцалж, гэрээр цуцалсан өдрөөс хойш нэг жилийн хугацаанд дахин сонгон шалгаруулалтад оролцох эрхийг түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээ авна.

9.2.Сонгон шалгаруулалт хийсэн ажлын хэсэг, гишүүдийн хариуцлагагүй байдлын улмаас сонгон шалгаруулалтад алдаа гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулийн хүрээнд хариуцлага тооцно.

9.3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас үндэслэлгүйгээр санхүүжилт авсан сувиллын газрын албан тушаалтан, хуурамч баримт бичиг бүрдүүлэн үйлчилгээ авсан хүнд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.4.Энэ журмын зөрчсөн байгууллага, хүнд холбогдох хууль тогтоомжинд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---